



# Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр ба Хүний эрх



## Одоогийн зохицуулалт

**“Захиргааны хэм хэмжээ тогтоосон  
шийдвэр гаргах журам”-ыг**


**Засгийн газрын тогтоол Засгийн  
газрын 2010 оны 5 дугаар сарын 19-  
ний өдрийн 119 дүгээр тогтоолоор  
батлагдсан**





# Одоогийн зохицуулалт

- “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр” гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд бусдаас заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, үйлчлэл нь олон удаагийн буюу байнга давтагдах шинжтэй, гадагш чиглэсэн шийдвэрийг;
- “Хуулиар тусгайлан эрх олгогдсон” гэж хуульд заасан тухайлсан асуудлаар нийтээр дагаж биелүүлэх журам тогтоохыг үүрэг болгож, эрх олгосныг;
- “Эрх бүхий этгээд” гэж Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга болон хуулиар хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахаар тусгайлан эрх олгогдсон газар, зөвлөл, хороо, төв, хүрээлэн зэрэг байгууллагыг;





## Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт тавигдах шаардлага

- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог үндсэн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн утгаар хэрэглэх;
- хэл найруулга нь товч тодорхой, монгол хэлний зөв бичих дүрмийн дагуу хоёрдмол утгагүй, ойлгоход хялбар байдлаар бичигдсэн, “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын баримт бичиг зохион бүрдүүлэх шаардлагыг хангасан байх;
- тухайн шийдвэрээр урьд гаргасан шийдвэрийг хүчингүйд тооцож байгаа, эсхүл түүнд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа бол энэ тухай заалтыг заавал тусгасан байх;





## Шийдвэрийн төслийг бэлтгэх, батлах үе шат

Шийдвэрийн төслийг бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх ба түүнд дараахь нөхцөл байдлыг тусгаж, танилцуулга бэлтгэнэ:

- шийдвэр гаргах үндэслэл, шаардлага;
- шийдвэрийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ;
- шийдвэр гарсны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөж болохуйц бүлгийг тодорхойлох;
- хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх;
- тухайн асуудлыг зохицуулж буй урьд нь батлагдсан шийдвэр байгаа эсэх;
- шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүү, эдийн засгийн тооцоо.



## **Шийдвэрийн төслийг бэлтгэх, батлах үе шат**

- Шийдвэрийн төсөлд олон нийтийн санаа бодлыг тусгах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулж болно.
- Хэлэлцүүлгийн явц, үр дүнгийн талаар тэмдэглэл хөтлөн гарсан саналыг шийдвэрийн төсөлд хэрхэн тусгасан талаар мэдээлэл бэлтгэнэ.





## Одоогийн зохицуулалт- Шийдвэрийн төслийг бэлтгэх, батлах үе шат

Шийдвэрийн төслийг нөлөөллийн шинжилгээний танилцуулга болон хэлэлцүүлгийн мэдээллийн хамт тухайн байгууллагын хууль зүйн асуудал хариуцсан нэгж /газар, хэлтэс/, мэргэжилтнээр заавал хянуулна.

Эрх бүхий этгээд нь шийдвэрийг баталснаас хойш ажлын арван өдрийн дотор хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлнэ.





## **Одоогийн зохицуулалт- Шийдвэрийг нийтэд мэдээлэх, хүчин төгөлдөр болох үе шат**

**ХЗДХЯ улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн шийдвэрийг бүртгэсэн өдрөөс хойш 10 хоногийн дотор "Хууль зүйн мэдээлэл" сэтгүүлд бүрэн эхээр нь албан ёсоор нийтлүүлэх бөгөөд шийдвэрийг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, албан ёсоор нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.**



**Хүчин төгөлдөр бус шийдвэрийг дагаж мөрдүүлснээс үүсэх үр дагаврыг шийдвэр гаргасан эрх бүхий этгээд хариуцна.**





## Одоогийн зохицуулалт

Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон шийдвэрийг энэ журмын дагуу хянуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.





## Одоогийн зохицуулалт- *Тусгай зохицуулалт*

Гамшгаас хамгаалах болон гамшиг тохиолдсон үед гаргасан шийдвэр нь нийтэд мэдээлснээр хүчин төгөлдөр болно.



Эрх бүхий этгээд дээрх үед гаргасан шийдвэрээ гарсан өдрөөс нь хойш ажлын 3 өдрийн дотор хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.




ХЗДХЯ нь шийдвэрийг хүлээн авснаас хойш уг шийдвэрийг бүрэн эхээр нь эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээ буюу [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) цахим хуудаст ажлын нэг өдөрт багтаан байршуулж, мөн “Хууль зүйн мэдээлэл” сэтгүүлд албан ёсоор нийтлүүлнэ.





## Одоогийн зохицуулалт- Бусад асуудал

- ХЗДХЯ нь шийдвэрийн улсын нэгдсэн санд байгаа хүчин төгөлдөр шийдвэрийн жагсаалтыг “Хууль зүйн мэдээлэл” сэтгүүлд жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор шинэчлэн нийтлүүлж байна.
- Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас дугаар олгон тэмдэглэл хийж хүргүүлсэн шийдвэрийн хувийг эрх бүхий этгээд сан бүрдүүлэн хадгалж, иргэн, хуулийн этгээдийг зохих мэдээллээр хангана.
- Сум, дүүргийн Засаг дарга шийдвэрээ баталснаас хойш ажлын 10 өдрийн дотор дээд шатны Засаг даргаараа дамжуулан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.





# Анхаарал тавьсанд баярлалаа

